# “Бурханы Адислалын Ачаар Би Өөрийн Хандивлан Оруулсан Үйлсээрээ Ажил дээрээ Хүндлэлийг Хүлээн Авав.”

Сүмд үйлчилэгч Сунг Хакуйн (15-р Сүмийн Салбарын Даехо ХХК-ын Судалгаа Хөгжилтийн Асуудлыг Хариуцсан Ерөнхийлөгч)



Би 1999 оны наймдугаар сард хөдөө аж ахуйн шинжлэх ухааны мэргэжлээр Доктрантурын зэргээ Сунгкункваны Их Сургуульд хамгаалсан. 2000 оны Долдугаар сараас эхлэн би Канад улсын Британийн Колумбиа Их Сургуульд болон Тайваны Үндэсний Судалгааны Төв дээр Хөдөө Аж Ахуйн болон Шинжлэх Ухааны Судалгааны Төв дээр зэргээ хамгаалах дадлагын дагуу ажиллаж байсан. Гурван жилийн дараа би Солонгос улсдаа буцаж ирсэн ба 2003 оны Зургаадугаар сараас 2007 оны Хоёрдугаар сар хүртэл Солонгосын Үндэсний Их Сургуулийн Хөдөө Аж Ахуйн болон Шинжлэх Ухааны Салбарт ажиллаж байгаад мал аж ахуй эрхэлсэн Даехо ХХК-д орж ажилласан билээ.

Даехо ХХК нь ‘Эрүүл Орчин Хангалуун Амьдрал’ хэмээх уриатайгаар ажилладаг ба мал аж ахуйн өвс тэжээлийн нөөц, бүтэц найрлага болон байгаль орчинд үл бохирдуулах бараа бүтээгдэхүүн шинээр бүтээх гол зорилго тавин ажилладаг. Чин сэтгэлээсээ хэлэхэд энэхүү чухал ажилд ороход тусласан Бурхан Тэнгэрлэг Эцэгтээ туйлын их баярлаж байгаагаа энэ дашрамд дурдан хэлмээр байна.

### Тийм пастор Солонгост байдаг гэж үү?

Эхийн хэвлийд байхаасаа эхлэн би Христийн амьдралаар амьдарсан боловч ямар нэгэн онцгой өвөрмөц сүнслэг зүйл миний амьдралд тохиолдоогүй билээ. Арван жилийн сургуульд би мотоциклоос унан авто машины аваарт орсон ба миний сүнс миний махбодиос салан одсоноо эргэн буцаж ирсэн билээ. Тэр үеэс л эхлэн би нүдэнд үл үзэгдэх сүнслэг ертөнц байдгийг мэдсэн юм. Гадаадад амьдарч байхдаа миний эхнэр болох тус сүмд үйлчилэгч И Сунгсоок маань чин сэтгэлийн итгэлийн амьдралаар манай сүмд амьдарч байсан ба биднийг хуримаа хийхээс өмнө тэрбээр намайг сүмдээ урин авчирч Доктор И Жэй руг гуайн Бурханы гайхамшгуудыг надад үзүүлэх боломж олсон юм.

Манмин сүмийн гишүүн болсон хамгийн гол шалтгаан маань 2002 оны аравдугаар сард би зурагтаар нийт 3 сая гаруй хүн цугларсан Энэтхэгт болсон 2002 оны агуу гайхамшигт их цуглаан, Эдгэрэлийн залбирал үзсэн юм. Тухайн үед би Тайванд байсан ба тэрхүү бичлэгийг видео бичлэгээр үзсэн юм. Хэдий асар хүчтэй бороо орж байсан ч Тэргүүн Пастор чин сэтгэлээсээ Бурханы сургаал номлолыг айлдан, залбирч байгааг хараад өөрийн эрхгүй сэтгэл хөдлөн, түүнийг ажиглаж байсан. Би дотроо, Ийм пастор Солонгос улсад байдаг юм уу? ‘Яагаад Солонгосот сүмийнхэн түүнийг тийнхүү урьд нь алдартай болгоогүй юм бэ?’ хэмээн бодож байв.

2003 оны гуравдугаар сард би Тайванаас Солонгос руу буцаж ирээд Манмин Төв Сүмдээ явж эхлэв. Би Христийн зөв зохистой амьдралаар амьдарч байсан гэж бодож байсан боловч миний итгэлийн өсөлтөнд их өөрчилөлт гарсангүй.

### Бурханы Ариун Үйлсийн Тусламжтайгаар Миний Амьдрал Өөрчилөгдсөн нь

2009 оны нэгдүгээр сард манай ээж бага ангилалттай хөхний хорт хавдраар оношлогдсон ба хагалгаанд оров. Эмнэлэгт 10 хоног болсны дараа ээж маань гэртээ харилгүй Сөүлийн Манмин Залбиралын Төвд болж байсан Эдгэрэлийн Цуглаанд миний эхнэрийн зааварчилгаагаар оролцож эхлэв. Тэгтэл гэмшлэлийн сүнс дээр ирж түүний залбиралыг мэдэрч эхэлсэн ба тэрбээр урьд өмнө хийж байсан гэм нүглээсээ ангижирав. Тэрбээр түүний хагалгаа хийлгэсэн биеийн хэсэгт ариун гэрэл нэвтрэн орж байгааг мэдрэв. Тэр үе мөчөөс эхлэн хөхний хавдар, үе мөчний өвчин болон хоёр өвдөгний өвдөлтүүд нь хүртэл алга болов. Хэдэн сарын дараа тэрбээр нэгдүгээр зэргийн хараа муу хэмээн оношлогдсон ба Муаны Ариун Рашаан Усыг (Египетээс гарсан нь 15:25) нүдэн дээрээ дусаасан ба тийнхүү удалгүй хараа нь эргэн оров. Мөн түүнчлэн орой болгон унтах үед нь хоолой нь бөглөрөн түгжирдэг байсан нь бүр мөсөн алга болсон байв. Тэрбээр Муаны Ариун Рашаан Усны фен нь болов. Мөн түүнчлэн миний хүү арьсны өвчилтөөс болж зовиурлан зовдог байсан ба Муаны амтат усанд орсны дараа эдгэрэн сайжирав. Эдгээр гайхамшигт зүйлсийн дараа би Бурхан байдаг гэдгийг бүрэн дүүрэн ойлгон мэдэж авсан ба миний амьдралд асар их өөрчилөлт гарсан юм.

### Доктор Сунг, Та Тушаал дэвшсэн нь!

Даехо ХХК-д ажиллахаар очсоныхоо дараа би шинэ бараа бүтээгдэхүүн бүтээхийг хүсч байв. Хэдий би хамтран ажилладаг хүмүүстэйгээ хүнд хэцүү, муу нөхцөл байдалд байдаг байсан ч Христийн үнэн дагалдагч болохоо харуулах гэж хичээдэг байв. Олон жилийн турш хичээнгүйлэн ажиллацгааж байсан хүч хөдөлмөрийнхөө ачаар дэлхийн эдийн засгийн хямрал болсон ч компанийхаа борлуулалтыг 20% өсгөж чадсан тул шинээр ороод удаагүй ажилдаа өндөр амжилт гаргаж чадав.

2010 оны хоёрдугаар сарын 15-нд Цагаан сарын Баяраар Тэргүүн Пастортай уулзах завшаан надад тохиолдов. Тэргүүн Пастораас Бурханы ерөөл адислалуудыг хүлээн авах тухай урьд нь уншиж байсан тул тийнхүү итгэлтэйгээр би түүнтэй мэндчилж гар барин ажлынхаа салбарт нэр хүндтэй болохсон гэж бодов. Тэгтэл тэр долоо хоногийнхоо дөрөв дэх өдөр нь Судалгаа Хөгжилийн Институтын Салбарыг Удирдах Төвд Ерөнхий Менежирээр дэвшин ажиллахаар тушаал гарав. Тэрхэн агшинд би “Бурханы агуу их хүч чадлыг эргэн санаж Бурхан миний хүссэний дагуу хүсэл зорилгыг минь биелүүллээ” хэмээн өөрөө өөртөө хэлэв. Бүүр гайхамшигтай зүйл юу вэ гэвэл энэхүү албан тушаалын орон тоо нь урьд нь орон тооны асуудлыг хариуцсан хүмүүсийн хуралдаан уулзалтан дээр ер яригдаагүй байсан ба энэ нь маш олон хүний гайхлыг төрүүлэв.

Ерөнхий менежир гэдэг албан тушаал нь манай лабораторит хамгийн өндөр албан тушаал байсан ба бас давуу тал нь цалинг өсгөж өгөв. Тиймээс би 3 жил уйгагүй хөдөлмөрлөсний минь үр дүнд ийнхүү тушаал дэвшсэндээ би маш их баяртай байна. Судалгааны Төвийн Институтын Менежир болон Судалгаа Хөгжилийн Удирдах Албаны Ерөнхий Менежир хэмээх хоёр албан тушаалыг хамтран эрхлэх нь бас бараг дээд удирдах зөвлөлийнхөнтэй адил төвшинтэй юм. Би компанид зохих байр суурь эзлэх болсондоо маш их баяртай байна. Зөвхөн байгаль орчинд сайн нөлөөтэй бараа бүтээгдэхүүн болон мал аж ахуйн үржил шим, бүтээмжтэй зүйлстэй харьцахаас гадна хоол хүнсний асуудлыг нарийн чанд сахин судалж, шинэ худалдан авагч болон дэлхийн гадаад орнуудад шинэ бараа бүтээгдэхүүнээ санал болгох гэх мэт ажил эрхэлдэг болов. Энэхүү гайхамшигт ерөөл ивээл үзүүлсэн Тэнгэрлэг Бурхан Эцэгтээ болон Тэргүүн Пасторынхоо залбирал адислалд маш их талархаж байнам.

## “20 Жилийн Турш Ханиад болон Хоолойнд Цэр Бүглэж Тарчилагдаж Байсанаас Ангижирсан нь”



Сүмд үйлчилэгч Парк Чанг хее (16-гийн 2-р Сүмийн Салбар)

Гучаад жилийн өмнө би амьд Бурхантай уулзаад сүрьеэ өвчнөөс ангижирсан ба Христийн дагалдагч болон аз жаргалтай сайхан амьдралаар амьдарсан юм. Хэдий тийм ч гэсэн Бурханаа хайрлах хайр болон миний итгэлийн амьдрал маань хөсөрдмөл байдалтай болов. Би ханиад болон хоолойндоо цэр буглах байдлаас болж маш их хүнд нөхцөл байдалтай байдаг болов. Миний туулсан өвчин зовлонг өөрийн биеэр амсаагүй бол хэн ч ойлгохгүй. Унтаж байхдаа цэр нөжиндөө баригдан амьсгалаа ч авч чадахгүй байгаагаас болж шөнө болгон сэрдэг байсан тул би байнга л ядаргаатай байв.

Би 2008 онд анх Манмин Төв Сүмд элсэж Христийн итгэлийн амьдралаар амьдарч эхлэв. Хэдий Бурханы агуу гайхамшигт адислалуудыг би нүдээрээ харж чихээрээ сонсож байсан боловч өөрийнхөө биеийн байдал дээр эдгэрэл адислалыг хүлээн авч чадахгүй байлаа. Хэд хэдэн удаа өөрийнхөө өвчин зовлонгийнхоо төлөө залбирал үйлдээд адислал авралыг хүлээн авч чадахгүй байсан тул би бараг бууж өгөхөд хүрэв. Хоёрдугаар сарын эхэн хавьцаа би Даниел оройн залбиралд очоод чин сэтгэлээсээ залбирахаа больсоныхоо төлөө нүглээ наминчилан залбирал үйлдэв.

Шинэ Жилийн Баяраар Эзэний ариусгасан өдөр итгэлтэй байх аваас адислалын залбиралыг хүлээн авбал Бурхан бидний хувиа хичээсэн зан болон архаг болон удамшлын өвчнүүдийг арилган үгүй болгох болно гэдгийг сонсоод би маш их гайхан баярлав.

Хоёрдугаар сарын 12-нд би сэтгэл зүрхэндээ итгэл найдварыг олож Ариун Библиэс уншаад унтав. Дуг нойрондоо зүүдлэхэд Тэргүүн Пастор миний гарыг минь алгуурхнаар атган надад хандан, “Үнд хайр,” болон “Өөрчилөлт” хэмээн хэлэв. Тэрхүү гайхалтай зүүднээсээ би маш сэтгэл хангалуун баяртайгаар сэрэв.

Сар шинийн баярын үеэр Тэргүүн Пастортайгаа уулзахад тэрбээр бидэнд адислалыг хайрлан залбирал үйлдэв. Бидний төлөө залбирсан агуу гайхамшигт залбиралыг ‘Амен’ хэмээн хүлээн аваад Тэргүүн пасторт хандан Бурхан намайг миний ханиад болон хоолойнд бөглөрөх цэрнээс намайг ангижируулна гэсэн итгэлтэйгээр гар барив. Миний хүссэний дагуу л миний ханиалгалт маань зогсож хоолойн дох цэр тэр өдрөөс эхлэн алга болов. Одоо би нам тайван, сайхан амран унтах болсондоо би туйлын их баяртай байна.

### Мөргөлийн цаг

| Мөргөл | Цаг |
|---|---|
| Их мөргөл | Ням гариг 10: 30 |
| Үдээс хойш мөргөл | Ням гариг 13: 40 |
| 3-дахь өдрийн мөргөл | 3 дахь өдөр 18: 00 |
| 5-дахь өдрийн мөргөл | 5 дахь өдөр 22: 00 |
| Хүүхдийн мөргөл | ням гариг 10: 30 |
| Сурагч залуучуудын мөргөл | Хагас сайн өдөр 16: 30 |

### Залбирлын цаг

| Ангилал | Цаг | Удирдагч |
|---|---|---|
| Даниел үүрийн залбирал | Даваа- баасан 05: 00- 06: 00 | Ш. Золзаяа (Том хүний баг хариуцагч) |
| Даниел өдрийн залбирал | Даваа- баасан 09: 00- 10: 00 | П. Уртнасан (2Том хүний баг хариуцагч) |
| Даниел оройн залбирал | Өдөр бүр 18: 30- 20: 00 | П. Батзориг (Чуулганы хариуцагч) |



Хаяг: Баянзүрх дүүрэг, 13-р хороолол 6-р хороо, ой булан- 6 иргэний А.О.С
Утас: чуулганы- 5525-7637 чуулганы хариуцагч- П. Батзориг 9117-0773
www.manmin.or.kr
www.manmintv.org


# Манмин Мэдээ

NO. 5 2010 оны 6 дугээр сар 27


# Муаны Гайхамшигт амтат усны 10 Жилийн Ойн Баярт Үйл Ажиллагаа

## Далайн шорвог ус амтат ус болон Хувирсан ба Ариун Сүнсний Үйл Ажиллагаа Илчлэгдсэн нь



Өнөөдөр Жеоннам Мужын Муан-гун Хаеже-муойн Чунжанг-ригийн Сан 153-д орших Муан Манмин Сүм дээр Бурханы агуу гайхамшгийн хүчээр далайн шорвог ус амтат ус болсныг үзэхээр маш олон Христэд итгэгч хүмүүс ирцгээдэг юм.

Дэлхийн маш олон хүмүүс Муаны Манмин Сүмээс зохион явуулсан Муаны амтат усны 10 жилийн Нээлтийн Үйл ажиллагаан дээр Доктор Естер Чунг “Чонг Гу ёнг” гуайн Муаны амтат усны гайхамшгийн тухай сонсогч олондоо хандан айлдсанаар Бурханы агуу гайхамшгийн хүч чадлуудыг олж авцгаав. Тус үйл ажиллагааны дараа тухайн тэмдэглэлт газарт зориулсан урлагийн тоглолтууд болж өнгөрөв.Хэдий далайн усаар хүрээлэгдсэн ч гэсэн Муан Манмин Сүм маань (Пастор Ким Мёнгсул) ундаа усны дутагдалтай байдаг байв. Бурханы агуу гайхамшгийг тэр сүмийн гишүүд чин сэтгэлээсээ Бурханд хандан залбирал үйлдэхэд Доктор И Жэй руг гуайн агуу гайхамшигт хүч чадлын хүчит залбиралаар 2000 оны гуравдугаар сард далайн ус нь амтат ус болон хувирав. Тэд нар Ариун Библийн нэгэн гайхамшиг болсон Марагийн шорвог усыг амтат ус болгосон Мосегийн залбиралд итгэсний улмаас тийнхүү гайхамшиг биелсэн билээ. (Египетээс гарсан нь 15:25). Зөвхөн Далайн шорвог ус амтат ус болоод зогсохгүй агуу амтат усаар олон сайхан гайхамшгууд бий болцгоосон билээ. Тэрхүү амтат усыг итгэн хүртсэн хүмүүсийн өвчин зовлон эдгэрч тэдний хүсэл эрмэлзлийн дагуу агуу гайхамшигт зүйлс тохиолдсон юм.

2006 оны арванхоёрдугаар сард Ерөнхийлөгч Чунг Чарлес ахлагч гуайн удирдлагаар Муаны амтат усны удирдах хороо анх байгуулагдсан билээ. Муан амтат ус нь шинжлэх ухаанаар чанарын өндөр шаардлага хангасан ус болох нь тогтоогдов. Муан амтат ус хариуцах хорооноос Муан амтат усны дээжийг АНУ-ын Хоол Хүнс ба Эмийн Шинжилгээний Алба уруу (US-FDA) явуулан шинжилгээ хийлгэхийг хүсчээ. Тус шинжилгээний үр дүн нь дэлхий дахинаа алдартай Франц болон Германы булаг, голын усны чанарын төвшингөөс хэд дахин өндөр үзүүлэлттэй гарсныг онцлон тэмдэглэсэн билээ. Муан амтат усны хариуцах хорооныхон усны чанарыг өндөр төвшинд байлгахын тулд байнга шинжилгээ болон хяналт шалгалт хийдэг бөгөөд Солонгосын худалдааны хуулийн эрх зүйн хүрээний дагуу эрх бүхий байгууллагуудтай хамтран ажилласаар байна.

Маш гайхамшигтай зүйлсүүдийн нэг юу гэвэл далайн загас болон цэнгэг усны загас жараахайнууд хамтдаа Муаны усанд амьдарцгааж байгааг олж илрүүлсэн явдал юм. Газар зүйн байрлал болон орон зайн нөхцөл болоод зарим загаснууд хамт амьдарцгааж чаддаггүй байдаг. Хэдий тийм ч гэсэн ойролцоогоор 400 гаруй төрлийн далайн (давст) усны загаснууд болох хоунд акул болон карп мандарин загаснууд Манмин Төв Сүмийн Муаны амтат усны Аккуариумд амьдарцгааж байгааг олж харж болно. Өнөөгийн байдлаар 120 төрлийн далай тэнгисийн болон цэнгэг усны загаснууд хамт амьдарцгааж байгааг харцгааж болно.



FDA-аас хийсэн шалгалтын үр дүнг 2007 оны аравдугаар сард Муаны амтат усны Удирдлагын хороо уруу илгээсэн нь

Энэхүү Бурханы агуу гайхамшигт хүч чадлыг үзэж харцгаахаар зөвхөн Солонгосын гишүүд ч биш дэлхийн маш олон орны жуулчид зочид хүрэлцэн ирцгээж байдаг билээ. Өнгөрсөн Долдугаар сард далайд орох амралтын газар бий болгон элс авчран далайн эргэ орчныг тохижуулсан билээ.

Жеоннам Мужын Төвийг Муан руу шилжүүлэн, Баруун Эргийн Хурдны замыг бий болгон, Муаны Олон Улсын Нисэх Онгоцны Буудал бий болгосон нь Муаны амтат усны газар нь дэлхийн олон орны Христийн итгэгчид хүрэлцэн ирцгээх дэлхий дахинаа алдаршсан газар болоход нөлөөлсөн юм.

# Пасторуудын “Загалмайн Сайн Мэдээ” Сургалт болон Непал /Балба улсын Ламжунг Дүүрэгт хийсэн Цуглаан

2010 оны гуравдугаар сарын 1-5-ны хооронд Непаль улсад “Ламжунг Дүүргийн Пасторууд” ‘Загалмайн Сайн Мэдээ’ ба ‘Өврийн Алчуурт цуглаан болон Семинар уулзалтууд’ явагдав. Тус уулзалтуудыг Непалын Сүмийн Удирдагч Симон Гурунг болон Непалын Манмин Номлолын Төвийн ерөнхийлөгч Сүмийн Удирдагч Грэйс Лее гуай тус тус удирдан зохион байгуулан явуулав. Гуравдугаар сарын 4-ны Пүрэв гаригт Сүмийн Удирдагч Грэйс Лее гуай Өврийн Алчуурт цуглааныг удирдан яваалахад Ариун Сүнсний гайхамшигт үйлсүүд үйлдэгдэв. Сүмийн Удирдагч Грэйс Лее гуай Бүхнийг Бүтээгч Бурхан болон “Есүс Христ” хэмээх сэдэвт сургаал айлдсаны дараа тэрбээр хуран цугларагсдад хандан Их Эзэнийг болон Ариун Сүнсийг хүлээн авцгаахыг уриалав. Хүрэлцэн ирэгсэд анхандаа тус сургаалыг сайн ойлгож хүлээн авахгүй байсан боловч сүүлдээ сэтгэлийн үүдээ нээн зөөлөрч, уйлан дуулцгааж “Амен” хэмээн өгүүлж хүлээн авцгааж байв. Сүмийн удирдагч Грэйс Лее гуайг Бурханы хүч чадалт алчуурт залбирал үйлдэхэд (Үйлс 19:11-12) Мекрас Бишхвокарма (70 настай эр) арьсны түлэгдэлтээс, Буд Маяа Шреста (44 настай эм) 12 жилийн турш өвчилж байсан арьсны загтналт өвчнөөсөө эдгэрсэн билээ. Мөн түүнчлэн, Гопал Сунувар (40 настай эр) хөл дээрээ зогсох боломжтой болсон ба Чандра Бахадур Бишхвокарма (46 настай эр) нар муу ёрын сүнсний авталтаас ангижирсан ба Бурханы алдрыг магтан дуулцгаасан юм.



Дагалдагч Грэйс Лее (зүүн талд) Ламжунг дүүрэгт зохион байгуулагдсан Өврийн Алчуурт Уулзалтын үеэр хуралдан цугларагсадад зориулан сургаал айлдаж байгаа нь

"Загалмайн Сайн Мэдээ"- цувралууд -(3)

# Төгс Хүчит Бурхан

"Үзэгтүн, Би бол Эзэн, бүх махан биеийн Бурхан. Надад ямар нэгэн зүйл дэндүү хэцүү юу?" (Иеремиа 32:27)



Доктор И Жэй руг

"Загалмайн Сайн Мэдээ" нь цаг хугацааны эхлэлээс өмнө нууцлагдсан Бурханы нууцлагдсан мэргэн ухаан юм. "Загалмайн Сайн Мэдээ" нь Бурханы хүн төрөлхтөнийг аврах төлөвлөгөөг хийгээд Бурханыг таньж мэдээгүй байгаа хүмүүст Түүнийг таньж мэдэн шинэ амьдралыг хүлээн авах болон Ариун Сүнсний гайхамшигт үйлсүүдийг таниж нүглээ наминчилан ариун адислал энэрлийг хүртэх зам юм. "Бурхан гэгч хэн бэ?" гэдгийг үнэн зөвөөр ойлгон авах нь Христэд итгэгч хүнд маш чухал явдал юм.

Бүхнийг Бүтээгч Их Эзэн маань мөнх чанараас өмнө өөрөө оршигч, юу ч үйлдэж бүтээж чадах Төгс Хүчит Бурхан билээ. Тиймээс Ариун судар дээр хүний хүч чадлаар бүтээн байгуулагдашгүй, үйлдэгдэшгүй гайхамшигт үзэгдэл ба тэмдэгүүдийн тухай тоймшгүй дурдан бичигдсэн байдаг.

Бурханы агуу гайхамшигт үйл ажиллагаа болон нөлөө цаг үе үед Бурханы хүмүүсээр илчлэгдэж Түүний хүч чадал өнөөдөр хүртэл илэрхийлэгдсээр байна. Есүс Иоханы 4:48-д, "Хүмүүс та нар хэрэв тэмдэг гайхамшигуудыг үзэхгүй бол ер итгэхгүй гэж айлдав." хэмээн хэлсэн байдаг ба хүмүүс Бурханы хүч чадлын гайхамшигуудыг үзэхгүй бол Бурханд итгэж чадахгүй.

### *1. Библи-д Тэмдэглэгдсэн Агуу Гайхамшигт Бурханы Хүч Чадал*

Бурханы агуу хүч чадлын талаар Библи дээр дурдахдаа, Улаан Тэнгис хоёр хуваагдаж байсан болон нар сар хөдлөхгүй мэлтийн тогтсон тухай дурдсан байдаг. Гурван жил хагасын урт хугацааны турш ган гачиг болсон газарт маш их хэмжээний хур бороо орж, Бурханы хүч чадлаар тэнгэрээс гал буусан тухай бас дурдсан байдаг. Бурханы хүч чадлыг гүйцэтгэгч нь Есүс байсан ба Тэрбээр Бурханы хүчээр нас барсан хүнийг амилуулж, өвчтэй хүмүүсийг эдгээж, тэнгисийн салхи намжаан мөн усан дээр алхах гэх мэт. Есүсийн дахин амилалт болон тэнгэр өөд өргөгдсөний дараа ч гэсэн Есүсийн дагалдагч нараар Бурханы хүч чадлууд илэрхийлсэн билээ. Дагалдагч Петрийн хувьд гэхэд хүмүүс өвчтэй хүмүүсийг дэвсгэр дээр хэвтүүлэн Петрийн сүүдэр нь тэдгээр өвчтэй хүмүүс дээр тусаасай хэмээн найдан гудамжинд гаргацгааж байв (Үйлс 5:25). Дагалдагч Полын тухайд гэвэл Түүний зүүж мөн хэргэлж байсан алчуур хормогч нь хүртэл хүмүүсийн өвчинг эдгээн, бузар зүйлээс ангижираах гайхалтай хүч үйлсэнийг харж болно (Үйлс 19:11-12).

### *2. Өнөөдөр ч нэгэн адил Бурханы Агуу Хүчээр бий болгогдож байгаа Эдгэрэлтүүд, Тэмдэгүүд болон Байгалийн үзэгдэлүүд Тохиолдсоор л байна*

Есүс Христ өчигдөр ч , өнөөдөр ч хэвээрээ бөгөөд мөнхөд хэвээрээ байдаг ба Бурхан Есүс Христээр агуу гайхамшигуудыг бий болгосоор байдаг хэмээн дурдсан байдаг (Еврей 13:8). Өнөө үед Ариун Сүнсний агуу үйл ажиллагаагаар бий болсон гайхамшигийг "тэмдэгүүд" гэж нэрлэцгээдэг.

Бурханы чадал хүч цаг агаарыг өөрчилөх хүртэл "үзэгдэл" явдал байдаг. Жишээлбэл: Чадал хүчээр хур бороог зогсоох, хүчит салхийг намжаах, далайн хар шуургын чиглэлийг өөрчилөх эсвэл үгүй болгох, цэлмэг өдөр Солонго татах, цэлмэг тэнгэрт гэнэт үүл хуримтлуулан хур бороо оруулах зэрэг.

Бурханы агуу чадал хүч нь Ариун Сүнсний тусламжтайгаар эдгэрэшгүй болон эдгэрэх найдваргүй хорт хавдар, ДОХ, цусны цагаан бөөм болон олон бусад өвчинүүдээс ангижирах боломжтой билээ. Бурханы чадал хүчээр Есүс өвчинд баригдсан хүмүүсийг эдгээн чөтгөрийг хөөн эрүүл болох ба нас барсан хүнийг дахин амьдруулсан билээ.

Бурханы агуу гайхамшигт нөлөө нь Манмин Жоонг-анг Сүмийг анх байгуулагдсан цагаас өнөөг хүртэл орон нутаг, дэлхийн олон орны хүмүүст нөлөөлж эдгэрэшгүй өвчин зовлонгоос ангижируулсан гайхамшигт үйл явдал явагдсаар байна. Тэр тусмаа надаас шууд залбирал хүртэх биш интернет телевизээр адислалт залбиралуудыг хүлээн авцгааж орон зай цаг хугацаа үл хамааран Бурханы агуу гайхамшигуудын биелэлийг хүртдэг.

Олон жилийн турш хүүхэдгүй байсан маш олон хосууд үр хүүхэдтэй болцгоосон билээ. Хилийн чандаас гэхэд л өвчтэй зовлонтой маш олон хүмүүсийн фото зургуудыг е-майлээр болон факсаар хүлээн аван тэдгээр хүмүүсийн сайн сайхан, эрүүл мэндийн төлөө залбирал үйлдэхэд Бурханы агуу чадал хүч цаг хугацаа орон зайн хамааралгүйгээр шууд нөлөөлөн биелэлээ олцгоож байна.

Тэдгээр адислал эдгэрэлүүдийг хүлээн авцгаасан хүмүүсийн нэг нь Пакистан улсын Синтия хэмээх нэгэн охин "Целиак" гэдэг маш ховор тохиолддог халдварт өвчинд нэрвэгдсэн байв. Синтия охины тамир тэнхээ нь доройтож, бие улам муудаж байсан тул эмч нар ямар ч найдваргүй хэмээн хагалгаа хийхээ больсон байв. Тэр үед Синтиягийн том эгч нь надад түүний зургийг авчирч залбирал хүртэв. Залбирал хийсэн тэр үеэс эхлэн Синтия охины биеийн байдал хэдхэн өдрийн дотор маш хурдан сайжирч тэрбээр удалгүй эмнэлгээс гарав.

Солонгост болон дэлхийн өөр оронд цуглаанд залбирал хийх үед би бүх хүмүүсийн толгой дээр гараа тавин залбирал үйлдэх боломжгүй тул индэр дээрээс бүгдэд нь хандан залбирал адислал үйлддэг. Олон хүмүүс залбирал адислалын үед Бурханы ариун агуу чадал хүчээр адислал эдгэрэлийг хүлээн авцгаадаг билээ.

"2004 оны Перу улсын Нэгдсэн Их Цуглаанд "-д 21-н настай Иммануел Маура гэдэг нэгэн залуу ДОХ-ын өвчинөөс бүр мөсөн ангижирсан юм. Нэгдсэн Их Цуглаанд анхны өдрөөс эхлэн Иммануел залбирал хүлээн аван, хүмүүсийн гэрчилэлүүдийг сонсон эдгэрнэ гэсэн итгэлтэй ч байв. Эдгэрэлийн хоёр дахь өдөр сургаал номлолыг сонсож байхдаа түүний бие болон гэдэс нь гэнэт эвгүйрхэн гүйлгэж эхлэсэн ба энэ байдал хоёр сар хагас үргэлжилсэний эцэст ДОХ-ын эсэргүүцэх сөрөг эсийн үзүүлэлт хэвийн байв. Тун удалгүй эмчийн үзлэгэнд орон шинжилгээ өгөхөд шинжилгээний хариу нь эрүүл хүний бие организмтай адил шинжилгээний хариу гарав. Иммануелын эмээ нь түүнтэй хамт цуглаанд ирсэн ба гурав дахь өдөр савны хорт хавдараас ангижиран доогуураа цус алдахаа больсон байв.

Хэдий Цуглаанд оролцож чадаагүй хүмүүс хүртэл интернэт болон сансарын хиймэл дагуулаар цацан түгээсэн нэвтрүүлгээр эдгэрэл адислалуудыг хүлээн авцгаасан хүмүүс маш олон.

Одоо, Бурханы "Байгалийн үзэгдэл"-ийн талаар авч үзье. Зуны налгар сайхан өдрүүдэд зохион явагддаг "Зуны цуглаан" дээр Манмин Жоонг-анг Сүмийн гишүүд Бурхан байгаль, цаг агаарыг удирдан байдгийг гэрчилсэн гайхамшигийг тоо томшгүй харцгаан мэдэрдэг. Үйл ажиллагаа гадаа зохиогдох үед шаагин орох хүчит бороог зогсоох болон аагим халуун нартай өдөр үүлсийг дуудан залбирах үед дөрвөн зүгээс үүл цуглан халуун нарыг халхалж хүсэлтийн минь дагуу биелэлээ олдог.

Хилийн чандад Цуглаан хийхээр явхад ч "Байгалийн үзэгдэл"-үүдтэй тохиолддог билээ. Жишээлбэл: "2001 оны Филиппинийн Нэгдсэн Их Цуглаан" явагдахын өмнөхөн хоёр хар шуурга Цуглаан болох газар руу чиглэн ирж байлаа. Хэвлэлийн бага хурал дээр "Далайн хар шуурга устан үгүй болно эсвэл чиглэл нь өөрчилөгдөн алга болох болно. Цуглаан болох газар ямар ч нөлөө үзүүлэхгүй байх болно" хэмээн итгэлтэйгээр би зарлан тунхагласан билээ. Тэрхүү хоёр далайн хар шуургын нэг нь далайн эрэг хүрхээсээ өмнө устан алга болсон ба нөгөө нь чиглэлээ өөрчилөн Филиппинид ямар нэгэн хохирол учируулсангүй.

Манмин Жоонг-анг Сүм болон сүмийн гишүүдийн өвчин ба сул дорой (төрлөхийн согогтой) байдал эдгэрэл болон агуу гайхалтай хүчит үйлс, тэмдэгүүд ба үүлс, одод болон төрөл бүрийн солонго зэрэг Төгс хүчит Бурханы баталгаа болгоныг тоочин хэлэх аргагүй юм.

### *3. Ирээдүйг Урьдчилан Хардаг Төгс Хүчит Бурхан*

Төгс хүчит Бурхан бүгдийг мэддэг ба Түүнтэй харилцаа холбоотой хүмүүст ирээдүйд болох зүйлсийг урьдчилан мэдүүлдэг(Амос 3:7). Библи дээр хүн төрөлхтөний Аврагчийн тухай болон Израилийн сүйрэл, босолт бас төгсгөл үед дэлхийн урсгал болон цаг хугацааны тухай зөгнөсөн ба тэдгээр нь биеллээ олсоор байдаг.

Өнөөг хүртэл Бурханаас Бурхантай холбогддог хүмүүсээр дамжуулан ирээдүйд тохтодох зүйлсийг мэдэгдсээр байдаг ба би индэр дээрээс Бурханы надад илчилсэн олон зүйлсийг дамжуулдаг өгдөг. Жишээлбэл, 1987 онд болсон ерөнхийлөгчийн сонгуульд Ну Тэе-воо Өмнөд Солонгосын ерөнхийлөгчөөр сонгогдох ба тэрбээр Ким Ёунг-сам болон Ким Дэе-жунг нарыг гарах болно гэдгийг урьдчилан хэлж байсан билээ. Мөнтүүнчлэн, Роналд Реаганыг Америкийн Нэгдсэн Улсын ерөнхийлөгч, Маргарет Татчер Вритан Нэгдсэн Вант улсын ерөнхий сайдаар томилогдох болно гэдгийг урьдчилан мэдсэн билээ. Бурхан бас надад Энэтхэгийн Ерөнхий сайд Индира Гандийг болон хуучин Зөвлөлт Холбоот улсын ерөнхий нарийн бичгийн дарга Черненког нас барах талаар урьдчилан мэдэгдсэн билээ.

1999 оны "Косовогийн хямралт байдлын" талаар зөгнөн хэлж байсан ба ирээдүйд ямар аймшигт айдас түгшүүр нүүрлэж байгааг урьдчилан хэлсэн . Мөнтүүнчлэн, Ойрхи Дорнодын улсуудын ирээдүйн нөхцөл байдал, газрын тосны үнийн өсөлт болон Америкийн Нэгдсэн Улс, Европын Холбооны орнууд болон хуучин Коммунист болон Коммунист удирдлагатай улс гүрэн хэмээх гурван том хүчин дэлхийн эрх мэдэл хүчний төлөө тэмцэлдэх тухай зөгнөн хэлсэн билээ. Өмнөд Солонгос улсын "гэгээн наран" хэмээх Хойд Солонгос руу чиглэсэн бодлого амжилтгүй болох талаар болон Хойд Солонгосын одоохондоо нээлттэй байгаа бодлого нь хочим үүд хаалгаа хаан улам алсгагдах болно гэдэг талаар зөгнөн хэлсэн билээ. Би маш олон сэдвүүдээр зөгнөн хэлж байсан ба тэдгээр маань бүгд биеллээ олцгоосон билээ.

Бидний хайрт Бурхан эцэг маань хүн бүрийн сэтгэл ба урдах өдрийг ч мэднэ. Өнөөгийн дэлхийн нөхцөл байдлыг сайн мэддэг ба ирээдүйд бидэнд юу болох талаар нэг бүрчилэн мэдэж байдаг билээ. Өөрсдийн амьдралаа Бурханд даатгасанаар үргэлж амжилтай, ерөөлийн замаар замчилагдахыг танд аминчилан захиж байна.

Христэд итгэцгээх хайрт ах эгч нараа,

Өнөөг хүртэл Амьд Бурханы маань хүний хувьд огт боломжгүй таних тэмдэг, гайхамшигт үзэгдэл болон зөгнөлүүдээр илчилэгдсээр байна. Агуу хүчит Бурханд итгэсэнээр эрхэм та Бурханд алдарыг зориулан аз жаргалтай амжилт бүтээл дүүрэн сайхан амьдралаар амьдарцгааж үй олон хүмүүсийг аврал уруу замчилахыг Их Эзэний нэрээр хүсэж байна!

Манмин Мэдээ
Published by Манмин Төв Сүм

235-3 Гуро-Здонг, Гуро-гу, Сеүл,
152-848 Солонгос Улс
Утас: 82-818-7047 • Факс: 82-2-2818-7048
http://www.manmin.org/english
e-mail: manminministry@hotmail.com

Нийтлүүлэгч: Жаерок Лее
Редактор: Геумсун Вин



# Манмин Олон Улсын Семинар (MIS) Дэлхийн Олон Орны Пасторуудыг Бурханы Ариун Сургаалаар Сургадаг

*"Юу гэвэл далай усаар дүүрэн байдгийн адил дэлхий ЭЗЭНий яруу алдрын мэдлэгээр дүүрэх болно." (Хабаккук 2:14)*



Доктор Чунг Естер
(MIS-ын Ерөнхийлөгч)

Маш олон пасторууд Манмин сүмийн удирдлагыг бишрэн гайхацгааж байдаг билээ. Эдгээр хүмүүс тэдний хот дүүрэгт сургалтуудыг бий болгоцгоон шашины гүн ухааны хүлээн авцгаахыг хүсэн хүлээж байдаг билээ. 2005 оны дөрөвдүгээр сарын 17 -ноос эхлэн тэр онд анх удаа Гадаад хүмүүст зориулсан номлогч нарын программ сургалтуудыг явуулах болсон. MIS-ын зорилго нь хүчирхэг шинэ пасторуудыг бэлтгэн гаргах хүсэл зорилготой байдаг ба тэгснээрээ тухайн Таван Гэрчлэлт Сайн мэдээ Бурханы сургаал номлолуудыг бусдад тараан түгээх боломжийг олгодог. Одоогийн байдлаар MIS- нь Библийн сургалтыг АНУ, Европ болон Латин Америкийн орнуудад явуулсаар байна. Семинар нь Бурханы хүсэл зорилго, Бурханы энэрэл хайрыг пастор болон сүмийн удирдагч нарт тараан түгээхэд оршдог юм.

Амийн үгээр сэргээгдсэн тэд тус сүмийнхээ гишүүдэд пасторын үүргийг чадварлаг гүйцэтгэдэг. Ингэснээрээ эдгээр хүмүүс маш олон хүнийг Бурханы жинхэнэ хүүхдүүд болгохыг зорин тусалдаг. Тиймээс MIS нь Бурханы сургаал номлолыг түгээн тараахад Их Эзэний дэлхийн ариун гэгээн номлолыг гүйцэтгэхэд маш их хувь нэмэр оруулсаар байна.

MIS нь Бурханы алдрыг магтан дуулсан агуу гайхамшигт сургалт юм. Ерөнхийлөгч Доктор Чунг Естер гуайг Христийн амьдралын тухай 'Загалмайн Сайн Мэдээ', 'Итгэлийн Сайн Мэдээ', 'Сүнс, ухамсар болон Махбодь', 'Тэнгэрийн орон', болон 'Там' хэмээх сэдэвт сургаал номлолуудыг айлдахад хэдэн зуугаас мянган пасторууд сүнслэг ертөнцийн ойлголтыг гүн ойлгож Бурханы хүсэл зорилгыг хүлээн авцгаасан ба Манмин Төв Сүмтэй хамтран ажиллах хүсэл төрцгөөдөг билээ. Олон зуун сүмүүд манай сүмийн салбар болон эсвэл хамтран ажилах хүслээ нуудаггүй юм.

MIS-ын төв нь Сөүлд байрладаг ба Белги, Англи, Орос, Энэтхэг, Хятад, Тайван, АНУ, Перу бусад орнуудад салбаруудтай билээ. Оюутнууд онлайнаар лекцүүдийг сонсож мэдэх боломжтой юм. Эрхэм та MIS-ыг www.manminseminary.org хаягаар орон гишүүнээр бүртгэлд бүртгүүлэж болно. Тус



Манмин Олон Улсын Семинарын (MIS) вебсайт

вебсайт нь Англи, Орос болон Испани хэлүүдээр уншиж сонсох боломжтой ба өнгөрсөн арванхоёр дугаар сараас эхлэн анхан шатны хичээлүүд Япон хэлээр явагдаж эхлэсэн билээ.

## Манмин Олон Улсын Семинарын

### Сургалт боловсролын үе шат

Нэг дамжаа нь 1 буюу 2 сарын хугацаатай байдаг ба тухайн дүүргийн пасторууд болон сүмийн ажилтан сүмийн удирдагч нарт зориулсан дамжаа сургалтууд байдаг. Хоёр жилийн сургалтын хөтөлбөрт дуусгасан оюутнууд тус семинарыг төгсөх боломжтой.

### Сургалт, хичээлүүд

MIS-ын анхан шатны хичээлийн сэдэв 'Загалмайн Зам,' 'Итгэлийн давхарга,' 'Сүнс, ухамсар болон Махбодь' ба 'Залбирал,' дунд шатны ангилалд:'Ариун Сүнс,' 'Үнэн Адислал' ба 'Хайрын Бүлэг' ба дээд шатны ангилалд: 'Тэнгэрийн орон,' 'Там,' 'Сүмийн Өсөлт Хөгжилт' ба 'Эхлэл' гэх мэт. 'Илчлэлт,' '1-р Коринт,' 'Иоб' хэмээх хичээлээс гадна 'Ээдрээтэй Асуудлуудыг Ойлгон Мэдэх' хэмээх сэдэвт лекцүүд ч байдаг. Оюутнууд анхан шатны бүх сэдэв ангиуд, дунд шатны ангилал, дээд шатны ангиллуудад сурахыг хүсдэг ба лекц, тусгай лекцүүдийг хүлээн авахыг сургуулийн захиргаанаас хүсэцгээдэг.

### Онлайны Лекцүүд, Хичээлийн Байрууд дахь Хичээлийн хөтөлбөрүүд

Анхан шатны ангиллын хичээлээ дуусгасны MIS-аас дараа шатны хичээлүүдийг авцгаахыг хүсэцгээдэг ба Даниел оройн залбиралд оролцсоны дараа манай сүм дээр ирцгээн Муаны Рашаан Усны газар хүрэлцэн ирцгээхийг уриалан дэмжиж байдаг.

## "MIS-аар би Бурханыг үнэхээр хайрлах юм бол Христэд итгэх амьдрал хялбар гэдгийг олж мэдэв."



Пастор Персиуал Ражадурай
(Мадурай Манмин Сүм)

Би Энэтхэгийн Мадурай Манмин Сүм дээр пасторын үүрэгтэй ажилладаг. Миний аав Пастор В Ражадурай нас барсны дараа би сүмийн үйл ажиллагааг удирдан авч явах болсон. Хэдий миний эцэг эх намайг сүмийн Их Эзэний туслагч болохыг хүсэцгээж байсан ч гэсэн би бүрэн итгэлтэй биш байв Гэвч миний амьдрал өөрчилөгдөөгүй байсан бол би сүмдээ тийнхүү үйлчлэх боломжгүй байх байсан. Би Христчин амьдралаар амьдарч байсан ч надад хариулт аваагүй маш олон асуудлууд байсан юм. Тэр үед Доктор И Жэй руг ын миний асуудлын хариултуудыг агуулсан агуу гайхамшигт номуудыг би уншсан билээ.

Би хамгийн түрүүнд Доктор И Жэй руг гуайн гэрчлэл дурсамж ном болох "Үхлийн Өмнө Мөнхийн Амссан Амьдрал" хэмээх номыг уншсан юм. Энэхүү номыг уншаад миний зүрх сэтгэл маш их хөдөлж би Доктор И Жэй руг гуайн заан тунхагласан Бурханы сургаалуудыг улам их судлан сурахыг хүсэж байв. Азаар би Энэтхэг дэхь MIS-ын сургуулийн хичээлийн байранд 'Загалмайн Сайн Мэдээ,' ном уншаад 'Эхлэл' сургаалыг сонсоод Мөнхийн Бурхан Эцэг маань бидэнд ямар их хайртай болон бидний авралын төлөө маш их гайхамшигтай зүйлс үйлдсэн гэдгийг Ариун Сүнсний тусламжтайгаар мэдэж авсан юм. Энэхүү гайхамшигт сургаалыг ойлгосноор өөрийн эрхгүй нулимс асгаруулав. 'Итгэлийн давхарга,' 'Тэнгэрийн орон I, II' болон 'Там' хэмээх номнуудыг уншиж байхад минь нулимс өөрийн эрхгүй мэлмэрч байлаа.

Өмнө нь би Христэд итгэх амьдрал маш хэцүү түүнийг амьдралд хэрэгжүүлэхэд боло дагаж мөрдөхөд маш хэцүү хэмээн боддог байлаа. MIS-ын сургалтанд хамрагдсаны дараа Бурханыг үнэхээр хайрладаг бол итгэлийн амьдрал нь тийм ч хэцүү биш гэдгийг ойлгож авав. Итгэлийн тухай буруу мэдээллүүдээсээ салах боломжтойг ухаарав.

Хэдий Ариун Библи Итгэлийн тухай маш сайтар тайлбарласан байдаг боловч би гүн гүнзгий ойлгодоггүй байв. Энгийнээр хэлэхэд, надад зөвхөн махан биеийн итгэл байсан ба Би тууштай байх итгэлийн тухай сайн ухаараагүй байв. Гэвч MIS-ын тусламжтайгаар "би хэн бэ" болон өөрт тохиолдсон хэцүү тулгамдсан асуудлуудаасаа хэрхэн ангижирах боломжтойг олж мэдэж авсан билээ. Бурханы сургаал номлолыг дагаж мөрдөхийн тулд бүх гэм нүглээсээ ангижиран цусаа урсгах мэт эцсээ хүртэл тэмцэх хэрэгтэй гэдгийг мэдэж авав.

Доктор И Жэй руг сүмийн сургаалыг өөрийн коллежийн Христэд итгэдэггүй нэгэн найзтайгаа хуваалцав. Тэрбээр Хинди шашинтай хүн байв. Доктор И Жэй руг гуайн гэрчилэл дурсамж ном болох Үхлийн Өмнө Мөнх Амьдрал Амссан нь хэмээх номыг түүнд өгсөн ба тэрбээр уншаад Есүс Христийг өөрийнхөө амьдралд хүлээн авсан ба дараа нь тэр номыг өөрийнхөө нэгэн хөрш найздаа өгсөн билээ.

Миний гол зорилго бол энэхүү ариун гэгээн сургаалыг Энэтхэгийн Өмнөд хязгаарын Тамил Наду мужид тараан тунхаглах байв. Мөн түүнчлэн, Христэд итгэгч гэр бүлд төрцгөөсөн хүмүүс ч гэсэн Бурханы үгийг нарийн сайн ойлгоогүй байгаа хүмүүст тунхаглан зарлах хүсэлтэй байв.

MIS болон ариун гэгээн сургаал номлолуудыг тунхаглан заасан, агуу гайхамшигт номуудыг бичсэн Доктор И Жэй руг гуай миний амьдралыг маш их өөрчлөн тусалсанд туйлын их талархаж байна.



Пастор Персиуал Ражадурай гишүүдийн хамт



Мадурай Манмин Сүм